

**10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ
ХУВИЛБАР Б**

Нийт оноо \40 оноо\

Хугацаа 80 мин

Эхийг уншиж ойлгон дараах даалгавруудыг зааврын дагуу гүйцэтгэнэ үү.

Эргүүлэг

“Нийгмийн хөгжил эргүүлэг хэлбэрээр явагдмуй” гэж тэртээ олон жилийн өмнө марксизмын хичээл дээр өвгөн багшаас анх сонсоод асар их гайхаж билээ. “Яагаад эргүүлэг хэлбэрээр хөгждөг юм болоо? Эрэгтэй хадаас шиг л үзүүр нь нарийхан, сүүл нь бүдүүн байх юм болов уу? гэж эргэлзэн боддог байлаа... Тэр цагаас хойш эргүүлэг маягийн хөгжил хувьслын тухай үргэлж эргэцүүлэн бодсоор өнөөг хүрэв. Эргэн үзвээс эргүүлгийн тухай миний балчир насны гэнэн ойлголт улам бүр гүнзгийрэн тэлсээр өнөөдөр огт өөр түвшинд гарчээ. Гэхдээ тэр мэдлэг бас ч эргүүлгийн хуулиар өсөж ирсэн мэт санагдана. Эргүүлгийг зөвхөн хийсвэр юманд биш харин амьдрал ахуйн хамгийн энгийн зүйлд олон тохиолддогийг одоо бид нэгэнт андахгүй болжээ.

Айл гэр болж, ууган хүүхэд төрж, түүнийгээ эхнэр бид хоёр ээлжлэн бүүвэйлж байх тэр аз жаргалтай мөчид эргүүлгийн тухай анхны нээлтээ би хувьдаа хийжээ. **Нялх бяцхан тэр амьтны зулайгаас хойш холгүйхэн хуруу дарам газар үснийх нь эргүүлэг тодоос тод харагдахад нь лавлан ажваас Адаг чулууны мананцрыг санагдуулам ажээ.** Орчлон хорвоод мэндлээд хэдхэн хоногийн нүүр үзэж байгаа тэр нялх амьтны зулай амьсгалахынх нь тоогоор үл мэдэг төвөлзөн хотолзож байхыг хараад гайхан, өрөвдөх сэтгэл төрсөн юм. Торгон сэвлэг үстэй тэр нялх амьтны цоорхой зулай нь нарийн хийцтэй цагийн амьсгалын утас шиг нэгэн хэмээр үл мэдэг мөртлөө жигдхэн бумбалзаж, судас, зүрхнийх нь цохилт, амьсгал гурав найран зохицож, бие биенээ давтаж байх ажээ. Анх удаа нялх хүүхдийн зулай тийнхүү битүүрч амжаагүй цоорхой тул амьсгаатайгаа зэрэг нааш цааш бамбалзаж байдгийг олж хараадаа дахин хэзээ ч мартахааргүй тогтоож, нялх хүүхдийг өрөвдөн хайрлах сэтгэлтэй болж, насан туршид минь тэр чигээрээ туйлбартай төлөвшөн юм. Зулай нь бамбалзаж, үсний эргүүлэг нь юу юунаас ч тодхон байх тэрхэн үед нь нялх хүүхдийн бяцхан толгойд юу эргэлдэж байдаг бол гэж тааж яддаг сан.

Хүний нийгэм байтугай хүн өөрөө эргүүлгийн хуулиар хүний биеийг олдгийн улмаас бие махбодын таван мөчийн төгсгөлд эргүүлгийн мөр үлддэг ажээ. Толгой дээрх үсний эргүүлгийг мөн гарын хуруу эсвэл хөлийн хуруу бүрийн өндгөнд давтан харж болно. Хүний мөч болгоны төгсгөл дэх эргүүлэг өвөрмөц бөгөөд бусадтай ижилдэн давтагдашгүй байх ёстой. Учир нь гарваль зүйн хуулиар байгаль эх давтагдахад хүрэхээргүй тийм баян, бүр төгсгөлгүй баян хувилбартай юм. Тэр үнэн гэдгийг амьдрал нотолжээ. Тэгээд л гэмтнүүдийг хурууных нь хуараар хөөж олдог болоо биз. Чухам юуны учир хүний биед төдий олон эргүүлэг байдгийг өчнөөн жил эргэцүүлэн бясалгаж явдаг сан.

Хүн ухаан зарж, эргүүлгийг ахуй амьдралдаа хэрэглэх арга бас сийлжээ. Шавар сав хийхэд эргүүлэг ашигласнаас хойш олон зуун өнгөрч, тэр арга эрэг шургийн хэмжээнд хүртэл боловсорч, их дэвшил хийлээ. Одоогоор бүхий л техникийн эд ангийг гол төлөв эрэг шураг, боолт, эрэгтэй хадаас л тогтоон барьж байна. Эрэг шургийн ухаан нээгдээгүй сэн бол хүн төрөлхтөн техникийн ийм дэвшил хийгээгүй ч сууж болох л байсан биз ээ. Эргүүлгийн ухаан улам задарч бууны гол төмөрт шилжсэн тэр л үеэс хүний нийгэмд гаслан тарьсан зэвсэг их хүчтэй болж, сумны хурд эрс нэмэгджээ. Зэвсгээр хөөцөлдөх өвчин улам даамжирч, эргүүлэг хэлбэрээр өссөөр өнөөдөр халуун цөмийн хуй салхи бөмбөрцөг дээр дэгдэх хэмжээнд хүрээд байна. Хэрвээ цөмийн дайн гаргалаа хэмээвэл хүний гараар бий болсон хамгийн том тэр эргүүлэгт бүх дэлхий сүйрэлд орох нь эргэлзээгүй юм.

Эргүүлгийн ёсыг хүний ахуйгаас нийгмийн амьдралд шилжүүлэн бодож болно. Тэгвэл мөн эргүүлгийн хэлбэрээр хүний нийгэм хөгжин дэвшиж, дээшлэх тусмаа хүчирхэг баялаг олон талтай болж ирсэн нь харагдана. Балар эртний хүй нэгдлийн нийгмийг боол эзэмшлийнх, дараа нь түүнийг феодлын нийгэм халан өөрчилж, улмаар капитализм ноёрхлоо тогтоож, октябрыйн их хувьсалаар социалист шинэ ертөнц мэндэлсэн. Хүн төрөлхтний шинэ түүхийн удиртгал болсон энэхүү хэвшлүүд эргүүлгийн адил доороос дээш өргөжин дэлгэрэх маягаар өсөн өндөрлөж иржээ. Гэвч хөгжих бүр дэвшилт ололтын хамтаар бурангуй зүйлийг агуулсаар байна. Нийгмийн шударга бус байдлыг халан өөрчилж эрх чөлөө, тэгш эрх, ах дүүгийн ёсны хаанчлалын үүдийг нээж, хүн нийгмийн өнөөг хүртэл тулсан замын дээд оргил хөгжлийн эргүүлгийн хамгийн том цагариг өөд бид явж байна. Гэвч тэр нь хүн төрөлхтний дэвшилийн замын төгсгөлд биш харин энэхэн замын дээд цагариг нь бөгөөд хүний нийгмийн жинхэнэ түүх эхлэх доод цагариг болно... Сансар эзэмшин, цөмийн эрчим хүч, лазерийн тuya, радио, электрон тооцоолол, мэдээллийн эрин үеийнхэн, биднийг залгамжлагч 800, 1000 дахь үеийнхэн өнөөдөртэй харьцуулшгүй хурдан эргүүлэгт орох нь дамжиггүй.

Л. Түдэв

1. Эсээний гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээрэй. \4 оноо\.....
 2. Дээд найруулгын үг хэллэг ашигласан хэсгийг олж бичээрэй. \4 оноо\.....
 3. "...Гэвч тэр нь хүн төрөлхтний дэвшлийн замын төгсгөлд биш **харин** энэхэн замын дээд цагариг нь бөгөөд хүний нийгмийн жинхэнэ түүх эхлэх доод цагариг болно..." өгүүлбэрт байгаа тодруулсан холбоос үг эхэд ямар үүргээр орсон бэ? Тайлбарлан бичнэ үү. \4 оноо\.....
 4. Эхэд ... цуваа гурван цэгийг ямар үед ашигласан байна вэ? \2 оноо\.....
 5. "Амьсгалахын" гэх үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаад, ижил дүрмээр бичигдэх үг нэгийг бичнэ үү. \2 оноо \.....
 6. Саран хөхөөний намтар" туужаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ жишээ баримт ашиглан 50-60 үгэнд багтаан бичнэ үү. \5 оноо \.....
 7. "Дасгал хөдөлгөөн ба эрүүл мэнд" сэдвээр өх зохион бичнэ үү. Үгийн тоо 180-200 /10 оноо /.....

8. Нацагдорж “Дөрвөн цаг” шүлгийн дараах мөрд юуг юутай адилтгасан бэ?
“...Өвлийн шөнө тэнгэрийн одод оч мэт гялалзахуйяа...” \2 оноо\

9. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлгийг зөв харгалзуулна уу. \2 оноо \
- | | |
|------------|----------------|
| 1. Өвөл - | A. Өсөх цаг |
| 2. Хавар - | Б. Өнгарөх цаг |
| 3. Зун - | В. Өтлөх цаг |
| 4. Намар - | Г. Идэр цаг |

10. Үндэсний бичгээс кирилд хөрвүүлэн бичээрэй. \5 оноо \
- Айл гэр болж, ууган хүүхэд төрж, тэгүн-и-бан эхэнэр бид хоёр эгэлжилэн бүбэилжүү байх тэрээ аз жиргалтаи мөчид эргигүлгэ-ийн тухай ангхан-у нээлтээ би хуби-ду-бан хийжээ.

10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ ХУВИЛБАР А

Нийт оноо \40 оноо\

Хугацаа 80 мин

Эхийг уншиж ойлгон дараах даалгавруудыг зааврын дагуу гүйцэтгэнэ үү.

Мацаг

“Мацаг барьж байна аа, хө” гэж нэг танил маань их л гунигтайхан өгүүлэв. Бид хоёрын яриаг хөндлөнгөөс сонсоод зогссон ач маань бүр хожим гэнэт нэгэн өдөр надаас хачин юм асуув.

-Өвөө, эртээрийн өвөө юу барьж байсан юм бэ? гэсэн тэр бяцхан хүний асууж байгаа юмны учрыг эхлээд би нэг их сайн ухаарсангүй.

-Ямар өвөө, юу барьж байлаа? гэж би эргүүлээд лавлан асуухад хүрлээ. Ачийн маань сониуч нүд нь юм горьдсон мэт дүрлийж басхүү гайхаш төрсөн нь илэрхий.

-Яагаа вэ дээ, эртуудийн дайралдсан өвөө нэг хачин юм барьж байна даа хө гээд танд хэлээд байсан. Тэр нь юу байсан юм бол? гэж лавлахад нь бодоод бодоод санаанд ордоггүй. Тэгэхээр ойрын өдрүүдэд хэн хэнтэй таараплданаа эргэцүүлэн бодлоо. Тэгтэл ашгүй тоотой хэдхэн хүнтэй дайралдсаны нэг нь санаанд ороод ирлээ.

“Мацаг барьж байна аа, хө” гэж тэр гунигтайхан хэлж байсныг санав.

-Мацаг барьдаг өвөө юу? гэж би ачаасаа лавласан чинь тэр ихэд баярлан цовхчиж:

-Тийм шүү дээ, тийм шүү дээ! Мацаг гэж тэр өвөө юу барьж явсан юм бэ? гэж шулганав.

-Аа мацаг уу? гэж би дахин лавлаад “Нээрээ мацаг... Тэрийг чинь одоо юу гэж тайлбарлах билээ?” гэж эргэлзэн бодолхийлэв. Одоогийн жаалууд бүү хэл миний үеийнхэн тэр “мацаг барих” гэгчийг барахгүй сүүгээр архи нэрдэг эрдэм сурчээ. Зөвхөн сүм хийдэд шавилан суусан лам нар “мацагладаг” биш, харин ч монгол хүн болгон зуны гурван сард зарим нь бүр зун, намрын зургаан сард мацаг барьдаг байлаа. Өвлийн цагт л өдөрт ганц удаа махан хоол иддэг байсан дэглэм нь эвдэрч өвөл зунгуй өдөр бүр гурван удаа махан хоол зооглоо “махчин” журамд шилжсэнээс үүдээд нэн олон хүн махны муунхаг болж хоолны гэмээр тэнэгэрсэн учир сэтгэцийн өвчтөн олширч тийм хүний эмнэлгүүдийг дагнан байгуулахад хүрсэн билээ. Монгол хүн бие махбод, байгаль орчин нь өөрчлөгдөөгүй хэвээрээ байхад хоолны орцоо бараг мэдэхээ болж, мацаг барих сахилтнууд үгүй болоод бараг хагас зуун жил өнгөрч орхисон хэрэг. Манай найз ч мацаг барих настын хүн биш. Харин “мацаг барьж сууна” гэж ярьсан нь үнэн хэрэгтээ “мах олдохгүй болж, цагаан хоолонд орлоо” гэдгээ л хуучны үгээр ёжлон хэлж байсан билээ. Урьдын цагт бол лам нар махан хоолыг тэвчиж тодорхой хугацаанд “мацаг барих” сахилтай байсан ажээ.

Мацаг барьж байгаа хувраг хүн махан хоол иддэггүй, ялангуяа үдээс хойшийн хоолондоо мах оруулахыг татгалздаг байжээ. Тэгээд л “мацаг барих”, “мацагтай”, “мацаглах” гэсэн ойлголт буй болжээ. “Мацагтай хүн” гэж ерөөсөө мах иддэггүй дан цагаан идээгээр хооллодог хүнийг хэлдэг байжээ.

Өрнөдийнхөн махнаас зайлсхийж ногоонд шүтдэг байхад монголчууд махнаас татгалзахдаа “ногоон” биш сүүн тэжээлтэн болон хувирдаг байж. Сүү цагаан идээгээрээ төрөл бүрийн хүнс хоол бэлтгэхээр өөрчилсөн учир лагшин нь аажмаар хямарч янз бүрийн эмгэгтэй болжээ.

“Монгол хүн жар хүрээд ухаан сууж жаран нэгтэй өөд болдог” гэсэн гашуун үг гарчээ. Гэтэл жаран нас гэдэг бол байгалиас хүнд заясан настын яг тал нь юм. Аль ч шашны хөлгөн сударт хүнийг 120 наслах тавилантайг дурджээ.

“Мацаг” барихгүйгээс эртний Римийн гүн ухаантан Сенекагийн айлдсанаар “Хүмүүс үхдэггүй. Харин өөрсдөө өөрсдийгөө егүүтгэдэг” гэгч болж байдаг ажээ. Бүх өвчний 99 хувь нь зүй бусаар буруу хооллосноос үүдэлтэй байна гэдгийг одоогийн шинжлэх ухаан нотолжээ. Хоолны хордлого бол монголчуудын тэргүүн зэргийн эрлэг нь бодоод байна. Үүнээс аврах хамгийн сайн, хамгийн хямдхан хэрэглүүр бол мацаг барих арга байж мэднэ.

Монголчууд мацаг барих нарийн дэг журamtай байсан аж. Хүний хodoодонд 42 балга шингэн орох багтаамжтай гэж үзээд дөчин хоёр балга ус багтах хэмжээтэй шавар аяга бэлтгээд тэрүүнээсээ анхны өдөр 42, дараах өдөр нь 41, гурав дахид нь 40 гэх мэтээр хоног тутам нэг балгаар хорогдуулж хооллосоор 42 хоног өнгөрөхөд эцсийн ганц балгыг хүртэж аажмаар хodoодоо дасган мацаг барьдаг байжээ. Тийнхүү бие махбодоо хоолны хордлогоос цэвэрлэж авдаг байжээ. Харин малчин ард бол цагаан идээгээр улаан идээний “бузрыг” арилгадаг байлаа. Гэвч өнөөгийн хот суурин газрын монголчуудын дийлэнх нь хodoодныхоо боол болон хувирсан учир хоолны орцын гажуудалд орж дотроосоо хордож явдаг болжээ. Хоолныхоо орцыг хүнсний ногоо, цагаан идээ, мөөг жимс, загас, жараахай, бал бурмаар баяжуулж тэнцвэрийг нь мацаг барин тохируулж байхгүй бол монгол улсын бүх эмнэлгүүдэд одоо өдөрт дунджаар хорин мянган хүн хэвтэж дөрвөн мянган их эмч тэдэнд үйлчилж

байdag хэвтрийн үндэстэн болж хувирах үед бид явж байна.

“Мацаг барих”-ыг ач гуч нар маань сонирхож байгаа бол үндэстнээ аврах далд совин татаж байгаа нь тэр ээ.

1. Эсээний гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээрэй. \4 оноо\

.....
.....
.....

2. Дээд найруулгын үг хэллэг ашигласан хэсгийг олж бичээрэй. \4 оноо\

.....
.....
.....

3. “Монгол хүн жар хүрээд ухаан сууж жаран нэгтэй өөд болдог гэсэн гашуун үг гарчээ. Гэтэл жаран нас гэдэг бол байгалиас хүнд заясан насны яг тал нь юм” гэсэн өгүүлбэрт байгаа тодруулсан холбоос үг эхэд ямар үргээр орсон бэ? Тайлбарлан бичнэ үү. \4 оноо\

.....
.....
.....

4. Эхэд анхаарлын тэмдгийг ямар үед ашигласан байна вэ? \2 оноо\

.....
.....
.....

5. “айлдсанаар” гэх үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаад, ижил дүрмээр бичигдэх үг нэгийг бичнэ үү. \2 оноо \

.....
.....
.....

6. “Саран хөхөөний намтар” туужаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ жишээ баримт ашиглан 50-60 үгэнд багтаан бичнэ үү. \5 оноо \

.....
.....
.....

7. “Дасгал хөдөлгөөн ба эрүүл мэнд” сэдвээр эх зохион бичнэ үү. Үгийн тоо 180-200 /10 оноо /

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

8. Д.Равжаагийн “Үлэмжийн чанар” шүлгийн дараах мөрд юуг ютай адилтгасан бэ?

“...Хөшүүн сэтгэлийг уяруулагч
Хөхөө шувууны эгшиг шиг
Хөөрхөн эелдэг үгс чинь
Хүүрнэн суухад урамтай...” \2 оноо\

9. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлгийг зөв харгалзуулна уу.

- | | |
|------------|----------------|
| 1. Өвөл - | A. Өсөх цаг |
| 2. Хавар - | Б. Өнгарөх цаг |
| 3. Зун - | В. Өтлөх цаг |
| 4. Намар - | Г. Идэр цаг |

10. Үндэсний бичгээс кирилд хөрвүүлэн бичээрэй.

“Монгол хүн жар хүрэгэд ухаан сагужу жиран нэгтэй өгэдэ болдог” гэгсэн гашигун үг гарчээ. Гэтэл-э жиран нас гэдэг бол байгали-ача хүнд зайагагсан насны яг тал нь йум.